



COVID-19 BOOSTER

LET'S DO THIS – Mongolian



16 болон түүнээс дээш насны иргэдийг COVID-19-н хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалтанд аль болох түргэн хамрагдахыг зөвлөж байн

Хүч нэмэгдүүлэгч тун яагаад хэрэгтэй вэ?

Та өмнө нь COVID-19-р өвчилсөн байсан ч, цаг хугацаа өнгөрөх тутам таны дархлаа буурч эхэлдэг болох нь судалгаагаар батлагдсан юм.

Хүч нэмэгдүүлэгч тун нь таны дархлалын системд тухайн вирусыг хэрхэн таньж илрүүлэн, устгах талаар үргэлж сануулж байдаг. Хүч нэмэгдүүлэгч тун нь таныг COVID-19-с шалтгаалсан ноцтой өвчлөлөөс 95% хүртэл хамгаална.

Хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалтанд хэн хамрагдаж болох вэ?

16 болон түүнээс дээш насны иргэд COVID-19-н вакцины хоёр дахь тунгаа хийлгэснээс хойш 3 сарын дараа хүч нэмэгдүүлэгч тунг хийлгэх боломжтой.

Эрүүл, залуу хүмүүс ч хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалтанд хамрагдвал зохино. Өвлийн улиралд вирусын халдвар авах эрсдэл өндөр байдаг тул та өөрийгөө болон эргэн тойрныхоо хүмүүсийг хамгаалахын төлөө таны хийж чадах энгийн алхам бол хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалтанд хамрагдах явдал юм.

Хэрвээ би аль хэдийн COVID-19-н өвчилсөн бол хүч нэмэгдүүлэгч тун хийлгэх хэрэгтэй юу?

Тийм. Ирээдүйн болзошгүй халдварын эсрэг тэмцэх байгалийн дархлааны түвшин хүн бүрт өөр өөр байдаг. Хүч нэмэгдүүлэгч тун нь ноцтой өвчлөлийн эсрэг таны хамгаалалтыг 95% хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

Та уг вирусийн халдвар авч, түүнээс бүрэн эдгэрснийхээ дараа хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалтанд хамрагдах боломжтой болно. Энэ нь ихэнх хүмүүсийн хувьд халдвар авснаас хойш 4-6 долоо хоногийн дараа байдаг.

Хүч нэмэгдүүлэгч тунд ямар вакцинууд хийгдэх вэ?

18 болон түүнээс дээш насны иргэдийн хувьд өмнөх хоёр тун нь өөр вакцин байсан ч, Pfizer болон Moderna mRNA вакцинуудыг хүч нэмэгдүүлэгч тунгаар хийлгэхийг зөвлөж байна. Pfizer нь 16-17 насны хүмүүст хүч нэмэгдүүлэгч тунгаар хийхэд хүлээн зөвшөөрөгдсөн вакцин юм.

Эрүүл мэндийн хувьд mRNA вакцин тохирохгүй, эсвэл тухайн хүн mRNA вакцинийг хийлгэхээс татгалзсан тохиолдолд AstraZeneca вакциныг хийлгэж болно. Хэрвээ тухайн хүнд COVID-19-н бусад вакцинуудын аль нь ч тохирохгүй бол Novavax вакциныг хийлгэж болно.

Хүч нэмэгдүүлэгч тун хийлгэснээр надад гаж нөлөө илрэх үү?

Хүч нэмэгдүүлэгч тун хийлгэсний дараа танд эхний хоёр тун хийлгэсний дараахтай төстэй нийтлэг, хөнгөн шинж тэмдгүүд илэрч болно. Үүнд гараар хөндүүрлэх, халуурах, булчин хөндүүрлэх, эсвэл ядрах мэдрэмж гэх мэт. Хэрвээ та энэ талаар санаа зовниж байгаа бол GP буюу Өрхийн эмчтэйгээ ярилцаарай.

Хүч нэмэгдүүлэгч тунд 16-с доош настай хүмүүс яагаад хамрагдах боломжгүй вэ?

16-с доош настай иргэдэд хүч нэмэгдүүлэгч тунг хийлгэхийг одоогоор зөвлөхгүй байгаа болно. Энэ насны бүлэгт COVID-19-с шалтгаалсан ноцтой өвчлөл ховор тохиолддог ба эхний хоёр тун нь хүчтэй дархлалын урвал үүсгэдэг.

Жирэмсэн үед хүч нэмэгдүүлэгч дархлаажуулалт хийлгэх нь аюулгүй юу?

Хүч нэмэгдүүлэгч тун нь COVID-19-н вакцины 2 тунд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдэд аюулгүй бөгөөд хийлгэхийг зөвлөнө.

Вакцин хийлгэснээр та хүүхдээ ч мөн хамгаалж байгаа хэрэг юм. Вакцинаас авч буй хамгаалалт нь таны хүүхдэд мөн дамждаг нь баримтаар нотлогдсон байдаг.

COVID-19-н вакцин нь жирэмсэн, хөхөөр хооллож буй үед, мөн жирэмслэхээр завдаж буй эмэгтэйчүүдэд аюулгүй болох нь олон тооны нотлох баримтуудаар баталгаажигдсан юм. Эдгээр нь таны нөхөн үржихүйд нөлөөлөхгүй болно.

Вакцины найрлаганд агуулагдсан орцууд надад тохирох уу?

COVID-19-н вакцинуудын найрлаганд агуулагдсан орцууд бүгд **Australian Register of Therapeutic Goods (Австралийн эм, эмчилгээний бүтээгдэхүүний бүртгэл)** дэх жагсаалтанд багтсан байдаг.

Австралид хүлээн зөвшөөрөгдсөн COVID-19-н аль ч вакцинд дараах орц агуулагдаагүй болно. Үүнд:

- > өндөг эсвэл амьтны гаралтай бүтээгдэхүүн
- > COVID-19-н халдвар үүсгэх ямар ч төрлийн амьд вирус
- > ямар нэгэн байдлаар таны DNA-д нөлөө үзүүлэх эсвэл холбогдох чадвартай
- > таныг хянан, мөшгих чадвартай зүйл агуулсан
- > зарим шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй хүмүүст тохиромжгүй

Хэрвээ та баяр ёслолтой холбоотойгоор мацаг барьж байгаа бол энэ нь COVID-19-н вакцин эсвэл хүч нэмэгдүүлэгч тун хийлгэхэд аюулгүй байх болно. COVID-19-н вакцин нь ходоодонд нэвтэрдэггүй тул таны мацаг барилтанд нөлөөлөхгүй.

COVID-19-н вакцин нь таны DNA эсвэл генд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй. Вакцин нь таны биед COVID-19-н эсрэг хэрхэн өөрийгөө хамгаалахыг зааж өгөх ба хэдэн өдрийн дараа биеэс гадагшилдаг. Эдгээр нь ямар нэгэн байдлаар таны DNA-д нөлөө үзүүлэх юм уу урвалд ордоггүй.

Хүч нэмэгдүүлэгч тунг заавал хийлгэх ёстой юу?

Үгүй, гэхдээ хэрвээ та вакцин хийлгэх боломжтой байж хоёр дах тунгаас хойш хүч нэмэгдүүлэгч тун хийлгэлгүй 6 сараас дээш хугацаа өнгөрсөн бол таны COVID-19-н дархлаажуулалт бүрэн биш хуучирсан ба хугацаа хэтэрсэн гэж тооцогдох болно.

COVID-19-н хүч нэмэгдүүлэгч өвлийн нэмэлт тун гэж юу вэ? Хэн хийлгэх ёстой вэ?

Зарим иргэд COVID-19-н халдварын улмаас хүнд өвчлөлд өртөх эрсдэл өндөртэй байдаг. Эдгээр иргэдийг хүйтний улирлаас хамаарсан өвчлөлөөс хамгаалахын тулд нэмэлт (хоёр дахь) хүч нэмэгдүүлэгч тун хийлгэхийг зөвлөдөг.

2022 оны 4 сараас эхлэн та COVID-19-н өвлийн вакцинд (хоёр дахь хүч нэмэгдүүлэгч) дараах тохиолдолд хамрагдах боломжтой болно.

- > 65 эсвэл түүнээс дээш настай
- > Уугуул болон Торрес Стрэйт Арлын 50 болон түүнээс дээш настай иргэд
- > Өндөр настны асрах газар эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрах газрын оршин суугч
- > 16 болон түүнээс дээш настай бөгөөд хүнд зэргээр дархлаа дарангуйлагдсан. Энэ бүлгийн хүмүүст өвлийн вакцин нь COVID-19-н вакцины тав дахь тун (үндсэн гурван тун, эхний хүч нэмэгдүүлэгч тун болон өвлийн тун) байх болно.

Та COVID-19-н өвлийн хүч нэмэгдүүлэгч тунг эхний хүч нэмэгдүүлэгч тунгаа хийлгэснээс 4 сарын дараа, эсвэл хэрвээ та эхний хүч нэмэгдүүлэгч тунгаа хийлгэснээс хойш COVID-19-н халдвар авсан бол COVID-19-н халдвар батлагсанаас хойш 4 сарын дараа хийлгэх боломжтой.

COVID-19-н өвлийн нэмэлт вакцинд хамрагдах боломжтой ихэнх хүмүүс ханиадны үнэгүй төлбөргүй вакцинд мөн хамрагдах боломжтой.

COVID-19-н болон ханиадны вакцин зэрэг хийлгэх нь аюулгүй юу?

COVID-19-н болон ханиадны вакцин зэрэг хийлгэх нь илүү амар бөгөөд аюулгүй юм. Хэрвээ та хоёр вакцинаа зэрэг хийлгэхийг хүсвэл GP буюу Өрхийн эмч эсвэл эмийн сандаа хандаарай.

Цаг товлон дархлаажуулалтанд хамрагдаарай

Хүч нэмэгдүүлэгч тунг эмийн сангууд болон GP буюу Өрхийн эмч нар дээр, мөн түүнчлэн NSW мужийн хэдэн мянган байрлалд цаг товлон хийлгэх боломжтой.

Ихэнх NSW Health клиникүүд урьдчилан цаг аваагүйгээр ирсэн иргэдийг хүлээн авдаг ба энэ нь та заавал цаг товлох шаардлагагүй гэсэн үг.

- > Цаг товлох газраа олох эсвэл [NSW Health дархлаажуулалтын](#) клиникт очоорой.
- > [Өөрт ойр байрлах клиник, GP буюу Өрхийн эмч эсвэл эмийн сангуудыг](#) олж цаг товлоорой.

Хэрвээ танд цаг товлоход туслалцаа хэрэгтэй бол National Coronavirus Helpline (Үндэсний Коронавирусын Туслах шугам)-ын **1800 020 080** дугаарт холбогдон, 8 гэсэн сонголтыг дарснаар орчуулгын үйлчилгээ авах боломжтой.